**БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮ, ЭД ХӨРӨНГИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТАД ДОТООД ХЯНАЛТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024.05.02

Байгууллагын албан хаагчдын эд хөрөнгө эзэмших картын хөтлөлт, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт хийх ажлыг байгууллагын даргын 2024.02.28-ны өдөр баталсан дотоод хяналт шалгалт хэрэгжүүлэх төлөвлөгөөний 10 дахь заалтад тусгасаны дагуу 2024.05.09-ны өдөр байгууллагын 2 албан хаагчыг түүвэрлэн сонгож эд хөрөнгө эзэмших картын тулгалтын ажлыг зохион байгуулан ажиллаа.





Үзлэг шалгалтаар Албан хэрэг хөтлөлт, архив хариуцсан ажилтан Т.Урантогос, Мэдээлэл, технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Мянганбаяр нарын нийт 21ш үндсэн хөрөнгө тулгалт хийж, дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөнд код наах – 9ш
2. Кодын зөрүүтэй үндсэн хөрөнгийг засварлах -2ш
3. Эд хөрөнгө эзэмших картад үндсэн хөрөнгө, бараа материалыг ялган төрөлжүүлэх

Иймд үзлэг шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах зөвлөмж чиглэлийг албан хаагч нарт өгч, биелэлтийг 2024.05.09 -10-ний өдрийн хугацаанд хангуулсан.









Тайлан гаргасан:
Мэргэшсэн дотоод хяналтын ажилтан: Б.Даваажаргал

# ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

**Байгууллагын шилэн дансны цахим хуудас нь:**

1. Төсөв, гүйцэтгэл
2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт
3. Бусад гэсэн гуртан дэд цэстэй.

1.**Төсөв,гүйцэтгэл:**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасаны дагуу сар бүр, хагас жил бүр, жил бүр, тухай бүр гэсэн хугацаанд мэдээллийг ил тод байршуулсан байна. 2023 онд нийт сар бүр 8, жил бүр 1, тухай бүр 13 мэдээллийг тус тус хугацаанд нь мэдээллэн ажилласан байна.



**2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээлэл:**

- Сар бүр 4, жил бүр 2, тухай бүр 8 мэдээллийг тус тус хугацаанд нь мэдээллэн ажилласан байна.



**3.Бусад:**

**-** Сар бүр 4, тухай бүр 22 мэдээллийг тус тус хугацаанд нь мэдээллэн ажилласан байна.



Шилэн дансны цахим мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хүрээнд үзэхэд **3** бүлэгт нийт **62** мэдээллийг хугацаанд нь оруулсан байна. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй байна.

Тайлан гаргасан:
Мэргэшсэн дотоод хяналтын ажилтан: Б.Даваажаргал